

үеийн тактикийг боловсруулах, бүртгэгдэж байгаа нийт гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гомдол мэдээллийн урсгал болон ажлын ачааллыг хянаж шинжлэх, байгууллагын үйл ажиллагааны талаарх маркетингийг хөгжүүлж цагдаагийн байгууллагад хандах тохиолдол, хууль зүйн үндэслэлийг сурталчлан, эрхээ хамгаалуулахаар төрийн байгууллагад хандаж байгаа иргэдийг чиглүүлэн туслах нь ч чухал байна.

Түүнчлэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчлийн талаарх болон нийгэм, иргэдийн санаа бодол, уур амьсгалыг тодорхойлох ажлыг эрчимжүүлэн явуулах, үүний тулд олон нийттэй төрөл бүрийн хэлбэрээр хамтын ажиллагаа явуулж, нийгмийн сөрөг үзэгдлийн нөлөөллийг бууруулах, мэдээлэлд суурилсан цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлагыг судлан ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа, харилцан дэмжлэг туслалцаа юунаас ч илүү чухал болох нь харагдаж байгаа юм.

Энэ илтгэлд дээр дурьдсанчлан бүтэц, стратеги, хууль эрх зүйн орчин, үйл ажиллагааны технологи, хамтын ажиллагааны шинэчлэлүүд хийгдсэний дараа хууль сахиулах үйл ажиллагаанд хүний оролцоог

аль болох багасган мэдээллийн технологид түшиглэн ажиллах, гэмт хэргийн ул мөрийг илрүүлж, бэхжүүлэх, хадгалах техник, тоног төхөөрөмж, программ хангамж, лабораторийн хөгжүүлэлтийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, практикт нэвтрүүлэх хэрэгтэй болно.

Мэдээж хэрэг бүх тоног төхөөрөмжийг нэг дор худалдаж авах боломжгүй. Ийм учраас нэг тоног төхөөрөмжийг худалдаж авч байхад, нөгөөдөхийг нь худалдаж авах судалгаа төсөл явагдаж байх гэх мэтээр үе шаттай, үндэслэл, тооцоо судалгаатай шинэчлэлт хийгдэнэ.

Жишээ нь, криминалистик шинжилгээний лабораториудыг хими, физик, адилтгалын төрлөөр байгуулж, магадлан итгэмжлэлд оруулах, шинжээч, мэргэжилтнийг бэлтгэх, явуулын лаборатори ажиллуулах, олон нийтэд үйлчлэх сэтгэл зүйн төвүүдийг аймаг, дүүргийн цагдаагийн дэргэд ажиллуулах, эдгээрийн санхүүжилтийг төсвийн додотголд тухай бүр тасралтгүй тусгуулж шийдвэрлүүлэх зэрэг шинээр бий болсон эрх зүйн таатай орчинд түшиглэн зохион байгуулах ажлууд биднийг хүлээж байна.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХАМГААЛАХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

SAFETY OF POLICE OFFICERS AND USING THE POLICE EQUIPMENTS



Н.Ганбадрал. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа
Ganbadral.N. Director of institute Police, Law Enforcement University, Ph.D, Police lieutenant colonel

Abstract: Under framework of the legal innovation, the improvement of legal environment of the Law enforcers has been developed. The legislations constituted the issues concerning to risk management of Law Enforcers. However, it still needs some further improvement. Any equipment and tools that are used to meet safety and security requirement of Law enforcer service shall reach internationally allowed standards moreover it would be right step to use those equipment and tools after we collaborate with professional laboratories and scientific institutes that are most suitable for our country's feature and specialties on investigation and research. Everything should be based on those research work.

Энэ хорвоод хүмүүний биеийг олж мэндэлж амьдарна гэдэг юутай ч зүйрлэшгүй хувь тавилан билээ. Тэгвэл амьдрахын тулд хүн бүхэн л ямар нэгэн байдлаар ажил хөдөлмөр эрхэлдэг бөгөөд тэрхүү хийж буй ажил нь гадна дотны янз бүрийн /таатай, таагүй/ нөлөөтэй байдаг нь тодорхой.

Английн философич Бэртран Рассель хүний хийдэг хөдөлмөрийг биеийн хүчний, оюуны хөдөлмөр гэж ангилсан байна. Энэ 2 төрлийн хөдөлмөрийн алийг нь ч эрхэлдэг бай тэрхүү ажил эрүүл, аюулгүй байх нь хүн төрөлхтөний хувьд амин чухал юм.

Өөрөөр хэлбэл, аливаа хөдөлмөрийн үйл ажиллагаандаа бүхэлд нь хөдөлмөрийн ёс зүйг баримталж, аюулгүй ажиллагааг сахин биелүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Ингэж байж л тухайн хөдөлмөрийг эрхэлж буй хүн урт удаан амьдарч өөрийн сайн сайхан хүсэл мөрөөдөл бүхий л зорилгодоо хүрч, хүний ёсоор амьдарна.

Дэлхийн улс бүхэн иргэнийхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах эрхийг нь хууль тогтоомжиндоо тусгасан байдаг. Хүн төрөлхтөний эзэмшсэн мэргэжлүүдээс хамгийн эрсдэл өндөртэй 10 мэргэжлийн эхэнд гүний уурхайчин бичигддэг агаад цагдаагийн мэргэжил уг жагсаалтад ордгийг олон олон судалгаа харуулдаг.

Тэрхүү эрсдэл, аюултай мэргэжлүүдийн аюулгүйн менежмент сүүлийн жилүүдэд дэлхий даяар хүчтэй яригдаж, хэрэгжиж эхлээд байна.

Тухайлбал: Герман Улсын хувьд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны менежментийг сүүлийн 30 жилийн хугацаанд хэрэгжүүлснээр осол эндлийг сүүлийн 15 жилийн хугацаанд 93%-иар бууруулсан байна.¹³⁶

Манай улс нь 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиар ардчилсан эрх зүйт төрийн үндсэн суурийг тогтоон бэхжүүлснээс гадна уг Үндсэн хуулийн зарчим, үзэл санааг иш үндэс болгон Монгол Улсын төрийн албан хаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг бүх талын баталгаатайгаар хуульчилж өгсөн билээ.

1994 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал ийнхүү түүхэн нэн чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд өдгөө манай улсын аюулгүй байдлын гадаад, дотоод нөхцөл байдал өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх шаардлага бий болсон юм.¹³⁷

“Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал”-ыг 2010 оны 7-р сарын 15-ны өдөр УИХ баталсан нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын чухал баримт бичиг болсон бөгөөд үүнээс үүдэлтэй аюулгүй байдлын салбар, эрх зүйн орчны өргөн хүрээтэй шинэтгэлийг эхлүүлж байна.

Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь

уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагуудын үүрэг хэмээн үзэж байсан ч шинэ нөхцөл байдал нь аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгөж, шинэчилсэн үзэл баримтлал нь хүн төвтэй, цогц, мэдлэгт суурилсан гэсэн суурь зарчмаар өөрчлөгдөж байна.

Аюулгүй байдалд хандах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томъёолж “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн буй орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” гэсэн зургаан чиглэлээр цогц хэлбэрээр харилцан уялдаатай хангах, нийгэм, иргэдийн хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах шаардлагатай болсон.

Иймд төр үндсэн үүргээ гүйцэтгэхдээ иргэдтэйгээ хамтрах, санал, бодлыг нь сонсох, тэднийг шийдвэр гаргах, хяналт тавихад оролцох боломжоор хангах арга хэмжээг авахаар үндсэн чиглэлээ тодорхойлж байна.

Хувь хүний аюулгүй, амгалан, эрүүл, хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийн сурвалж болж, энэ нь цаашлаад төр, улс, үндэсний аюулгүй байдлыг хангадаг.

Мөн төр, нийгэм нь аюулгүй байж иргэнийхээ аюулгүй байдлыг хангана гэсэн хүн төвтэй аюулгүй байдлын үзэл бөгөөд хүний амар амгалан, аюулгүй, эрүүл, хангалуун амьдрах, түүний хөгжих, хөдөлмөрлөх нөхцөл бүрдсэн, орлого, хүрээлэх орчин, хүнс нь аюулгүй байх цогц, бодитой, оновчтой шийдлийг тусгасан мэдлэгт суурилсан үзэл баримтлал юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4 /Хүний аюулгүй байдал/-д “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн”¹³⁸ гэж зааж өгсөн бөгөөд үүнийг хангах төрийн олон байгууллага дундаас иргэний гэмт хэрэг, халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх үндсэн үүрэг бүхий байгууллага болох цагдаагийн байгууллага онцгой үүрэгтэй оролцдог билээ.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д “төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно”, 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” –д “иргэдээ аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт

¹³⁶ Өдрийн сонин. 2014.03.19

¹³⁷ <http://www.nsc.gov.mn/?q=ns-concept>

¹³⁸ <http://www.nsc.gov.mn/?q=ns-concept>

хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарах, хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институци хоорондын уялдаа холбоог сайжруулна” гэж, 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх”-ээр тус тус тусгажээ.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг 1993 онд батлан гаргаж 1994 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд үүнээс хойш 20 гаран жил болж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг төдийлөн хангаж чадахаа байсан байна.

Өнөөдөр цагдаагийн албаны онцлогийг харгалзан алба хаагчид үүргээ биелүүлэх баталгааг төр хангаж өгөх ёстой гэсэн үзэл баримтлал хуулийн төслийг боловсруулах нэг чиглэл байж цагдаагийн алба хаагчдын үүргээ гүйцэтгэх баталгааг нилээд нарийвчлан, тэдгээрийн эрх зүй, эдийн засгийн баталгааг хуулиар тодорхойлж, цагдаагийн алба хаагчийн эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалж ирсэн.

Гэтэл улс орны нийгэм, эдийн засгийн байдал болон холбогдох бусад хүчин зүйлээс шалтгаалан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал жил ирэх тусам хүндэрч гэмт хэрэг, зөрчлийн гаралт тэр бүр буурахгүй байгаа өнөөдөр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн алба хаагчийн амь бие, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөөнд халдах, халдахаар заналхийлэх зэрэг гэмт хэрэг, зөрчил жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Үүнийг хууль сахиулах тусгай чиг үүрэг бүхий төрийн албан хаагчийнх нь хувьд Төрийн албаны болон Цагдаагийн албаны тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актад цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал хийгээд халдашгүй байдлын талаархи эрх зүйн баталгааг тусгасан боловч нэг талаас тэдгээрийн хэрэгжилт хангалттай бус түвшинд байгаатай холбон үзэж болно.

Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлын баталгаа тэр бүр зохих түвшинд хүрч чадахгүй алба хаагчид эрүүл мэнд, амь насаараа хохирсоор байна. Энэ нь 1960 оноос 59 цагдаагийн алба хаагчид үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан, сүүлийн 3 жилд халдлагад өртөж хохирсон 894 үйлдэл бүртгэгдсэний 641 буюу 71 хувьд нь захиргааны арга хэмжээ авч, 253 үйлдэл эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан¹³⁹ гэсэн статистик судалгаа тоо

мэдээнээс харагдаж байна.

Цаашид цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээг бодлогын түвшинд авч үзэх, эрх зүйн орчинг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага юм.¹⁴⁰

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг бүхий алба хаагчдад хамгаалах тусгай хэрэгслийг тавьж олгох бөгөөд уг тусгай хэрэгслийг тухайн алба хаагч нь ямар үндэслэл бүхий нөхцөл, байдал бий болсон, хэрэгцээ шаардлага, ямар ажиллагаанд оролцож байгаагаас хамааралтайгаар ялгамжтай байдлаар хэрэглэдэг.

Өнөөдөр “хамгаалах тусгай хэрэгсэл” хэрэглэх эрх зүйн үндэс нь “Цагдаагийн албаны тухай хууль”¹⁴¹ -ийн 6-р бүлгийн 28-р зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 38 тоот тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код-917 /Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам/-аар зохицуулагдаж байна.

Энэхүү журмаар хамгаалах тусгай хэрэгслийг дараах байдлаар томъёолж өгсөн байна. Тухайлбал:

“Хамгаалах тусгай хэрэгсэл” - тусгай үүрэгт ажил гүйцэтгэх явцад цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн эрүүл мэндэд учрах аюул, амь насаа алдах, хурц хордлогод орох зэрэг эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хувцас, өмсгөл, хэрэглэл

“Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” - үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл;

“Тусгай хувцас”-үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгсэл,¹⁴² гэж тус тус тодорхойлсон байна.

Уг журмын 917.4.4-д “Баривчлах, саатуулах, эрүүлжүүлэх байранд үүрэг гүйцэтгэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа, гэмт этгээдийг мөрдөх, онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, хуяглан хүргэх, гэмт хэрэг үйлдсэн сэжигтэй этгээдийг байж болзошгүй газарт нэгжлэг хийх зэрэг эрсдэл бүхий бусад ажиллагаанд хамгаалах тусгай хэрэгслийг заавал хэрэглэнэ” гэж зааж өгсөн нь алба хаагчдын аюулгүй байдлыг хангах талаар

¹⁴⁰ Цагдаагийн албаны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1 дэх хэсэг

¹⁴¹ Төрийн мэдээлэл, 2013 оны ., №29 /794/

¹⁴² “Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам” ЦБҮАЖ-ын 917.2 дахь хэсэг

¹³⁹ ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны тайлан.

тусгаж өгсөн маш чухал эрх зүйн зохицуулалт юм.

Өнөөдөр дор дурдсан нэр, төрлийн хамгаалалтын хэрэгслүүдийг цагдаагийн албанд ашиглаж байна. Үүнд:

а/төрөл бүрийн дуулга, иж бүрэн өмсгөл (мөр, тохой, шуу, эмзэг эрхтэн, гуя, өвдөг, шилбэ, гутлын хамгаалах хэрэгсэл);

б/бамбай;

в/бээлий;

г/хорт утаа, дуу, гэрлийн нөлөөнөөс хамгаалах баг, өмсгөл;

д/нүдний шил;

е/төрөл бүрийн сум, хутга үл нэвтрүүлэх, гэрэл ойлгогч хантааз;

ж/уналтаас хамгаалах олс болон хамгаалалтын олс бусад төхөөрөмж хамаарна.

Төрөл бүрийн дуулга, өмсгөл нь:

а/доргилт, тэсрэлтийн нөлөөнөөс хамгаалах;

б/сумнаас хамгаалах;

в/бусад хатуу биетээс хамгаалах.

Бамбай нь:

а/сум үл нэвтрэх /1, 2, 3 дугаар түвшний хамгаалалтын бамбай/;

б/бусад хатуу биетээс /1 дүгээр түвшний хамгаалалтын хуванцар бамбай/.

Бээлий нь:

а/хутганаас хамгаалах;

б/бусад.

Нүдний шил нь:

а/буудлага, тактик ажиллагааны аюулгүй байдлыг хангах;

б/цас, шороо, шуурганаас хамгаалах.

Төрөл бүрийн сум, хутга үл нэвтрүүлэх хантааз

нь:

а/1, 2, 3 дугаар түвшний сум үл нэвтрүүлэх хантааз;

б/хутга, тэсрэлт доргилт, цохилтын нөлөөнөөс хамгаалах хантааз.

Уналтаас хамгаалах олс, бусад төхөөрөмжүүд

нь:

а/олс, бусад бэхлэх төхөөрөмжүүд;

б/төрөл бүрийн зориулалтын шат гэсэн төрлүүдэд ангилагдаж байна.

Алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ аюулгүй байдлаа хангах нь хамгаас чухал бөгөөд албан үүргээ гүйцэтгэж байгаад амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал гарсаар байна. Тухайлбал: 2008-2012 онд захиргааны зөрчлийн халдлагад 552, гэмт хэргийн халдлагад 235 цагдаагийн алба хаагч өртсөн, 973 алба хаагч эрүүл мэндээрээ хохирсон стастистик судалгаа гарчээ.

1960 оноос хойшхи хугацаанд албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт этгээдийн болон бусдын гарт өртөж, авто осолд орж 59 алба хаагч амь насаараа хохирсон нь харамсалтай явдал юм.¹⁴³

Ажил мэргэжлийн эрсдэлтэй байдлыг судалсан

олон улсын судалгаагаар цагдаагийн ажил нь эрсдэлээрээ эхний дөрөвт багтдаг. Ийм аюул эрсдэлтэй тул цагдаагийн алба хаагч наад зах нь хөдөлмөр хамгааллын хувцас, албаны зэвсэг, тусгай хэрэгслээр хангагдах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Энэ тал дээр сүүлийн үед Цагдаагийн ерөнхий газар болон төр, засгийн зүгээс удирдлагын түвшинд нэлээд анхаарч, 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр УИХ-ын чуулганаар хэлэлцэгдэн батлагдаж, 2014 оны 1 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөж эхэлсэн “Цагдаагийн албаны тухай хууль”-иар алба хаагч нэг бүр тусгай хэрэгсэл, хамгаалах хувцас буюу хуулийн нэр томъёогоор агсамжийг албан үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэхээр заасан байна. Тухайлбал:

Цагдаагийн албаны тухай хуулийн 28-р зүйл /Алба хаагчийн агсамж/- ийн 28.1 “Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ”, 28.2 “Алба хаагч гүйцэтгэх үүрэг болон улирлын байдалд тохирсон дүрэмт хувцас, хутга, сум үл нэвтрэх болон гэрэлтүүлэгчтэй хантааз зэрэг хамгаалах хэрэгслээр хангагдсан байх бөгөөд гүйцэтгэх үүргийн онцлогоос хамаарч агсамжид багтах зүйлийг нэмж олгоно”, 28.3 “Алба хаагч нь амралтын цагаар, эсхүл энгийн хувцастай үүрэг гүйцэтгэх тохиолдолд хамгаалах тусгай хэрэгсэл, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч биедээ авч явж, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хэрэглэж болно” гэж зааж өгсөн нь цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалахад чухал ач холбогдолтой чухал заалт болсон гэж судлаачийн хувьд үзэж байна.

Гэвч өнөөдөр хамгаалах тусгай хэрэгслийг “Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”¹⁴⁴ -ийн 19-р зүйлд заасан “Тусгай хэрэгсэл” гэсэн нэр томъёонд тусгаж өгөөгүй нь ихээхэн учир дутагдалтай гэж үзэж болохоор байна.

Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж явах үедээ эрсдэлд оруулах магадлалыг албаны тусгай хэрэгсэл, тэр тусмаа хамгаалах тусгай хэрэгсэлийн чанаргүй, хэврэг байдаг нь алба хаагчдын эрсдлийг улам нэмэгдүүлж байгааг энд цохон тэмдэглэмээр байна.

“Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 20.1.8 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллагын зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хувцас бусад хангамжийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх”, мөн зүйлийн 20.1.9 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг

¹⁴³ ЦЕГ-ын хуулийн хэлтсийн судалгаа 2013 он

¹⁴⁴ <http://www.legalinfo.mn/law/details/9751?lawid=9751>

хамгаалах” гэж цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрхэд хамааруулж, алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах үүргийг шинээр хуулинд тусгаж өгсөн нь цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдлийг бууруулахад чухал ач холбогдолтой заалт болж чадсан гэж үзэж байна.

Мөн “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 30 дугаар зүйл /Цагдаагийн байгууллагын төсөв/-ийн 30.2 дах хэсэгт “Энэ хуулийн 30.1-д заасан шаардлагын хүрээнд цагдаагийн алба хаагчийн хүнс, эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, хамгаалах болон тусгай хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ”¹⁴⁵ гэсэн нь цагдаагийн байгууллагын болон алба хаагчийн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл боломжийг төрийн санхүүжилтээр хийгдэх маш чухал зохицуулалт болжээ.

Цагдаагийн албанд ашиглагдаж байгаа хамгаалах болон бусад бүх төрлийн тусгай хэрэгслүүдийг манай улс дотооддоо үйлдвэрлэдэггүй, гадаад улсаас импортоор оруулж ирэн ашигласаар байна.

Эдгээр гадаад орнуудаас оруулж ирсэн дээрхи тусгай хэрэгсэл манай орны байгаль, цаг уур, орчны онцлог нөхцөл байдлаас шалтгаалан чанарын шаардлага хангахгүй, энэ байдлаас улбаалан алба хаагчийн амь нас, аюулгүй байдалд сөрөг үр дагавар гарсаар байна.

Өнөөдөр манай улс өмнөд хөрш БНХАУ-ын тусгай хэрэгслийн үйлдвэрээс ихэнхи тусгай хэрэгслүүдээ захиалан авч албанд ашигладаг.

Гэтэл манай 2 орны байгаль, цаг уур, орчны нөхцөл харилцан адилгүй эрс тэс байдаг тул тэдний цэрэг, цагдаагийн албанд ашигладаг тусгай хэрэгслийн чанар стандарт нь манай орны нөхцөлд тэр бүр тохирохгүй, чанарын шаардлага хангахгүй гэж алба хаагчдаас гомдол гардаг.

Иймд цаашид өөрийн орны цаг агаарт зохицсон, бат бөх, чанартай хамгаалах болон бусад тусгай хэрэгслийг шинжлэн судлах, туршилт судалгаа явуулах шаардлага гарч байна.

Энэ талаар Хууль зүйн яам ихээхэн анхаарч, шинэчлэлийн бодлогын хүрээнд “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 5-р зүйлийн 5.5 хэсэгт: Цагдаагийн төв байгууллагын харьяанд судалгаа, сургалт дадлагын болон албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори, энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт хариуцсан нэгж байж болно” гэж хуульчлан тусгаж өгснөөр өнөөдөр Цагдаагийн байгууллага бодлогын түвшинд шинээр шинжилгээ, судалгаа төв байгуулахаар зохион байгуулалтын ажил хийж эхэлж

байгаа ба цагаа олсон, үр дүнтэй ажил болно гэдэгт итгэлтэй байна.

Харин энэхүү ажлыг дангаар бус ХСИС-ийн Шинжлэх ухаан технологийн газар, Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтрах нь оновчтой юм.

Цаашид олон улсын цагдаагийн байгууллагад ашиглагддаг чанарын стандарт шаардлага хангасан тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын автомашинаар хангагдах, алба хаагчдыг стандартын шаардлага хангасан хамгаалах хувцас, хэрэгслээр хангах явдал нэн тэргүүний чухал асуудал болоод байна.

2008 оны 7 дугаар сарын 1-нд нийслэлд болсон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үйл явдлаас болж цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагчид эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон нөхцөл байдлаас манай төр, засгийн удирдлага тодорхой үнэлэлт, дүгнэлт өгч, төсөвт тодорхой мөнгө суулгаж өгч байгаа нь бидэнд ихээхэн дэм болсон явдал гэж үзэж байна.

Засгийн газар энэхүү ажлыг бодлогын түвшинд дэмжиж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008-2011 онд утаан гранат, өнгөт утаа гаргагч, хорт утааны баг, сум шидэгч, нулимс асгаруулагч хий, сумнаас хамгаалах бамбай, түрдэг бамбай, хамгаалалтын бамбай, дуулга малгай, иж бүрэн хамгаалалтын хувцас, резинэн бороохой, цахилгаан бороохой, өдрийн дуран, шөнийн дуран, хаалга эвдэгч, цоож эвдэгч буу, авирах буух олс, хамгаалалтын тор, сумнаас хамгаалах хантааз, хутганаас хамгаалах хантааз, “Chey tac” буу, бууны сум, 38 мм-ийн буу, 88 мм-ийн сум, резин сум, станцны чихэвч, дохиур мод зэрэг нийт 80 нэр төрлийн 2 тэрбум төгрөгийн галт зэвсэг, хүн нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгсэл, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл авч, цагдаагийн байгууллага, алба хаагчдад хангалт хийсэн байна.

Ингэснээр нийт бие бүрэлдэхүүний буюу нийгмийн хэв журам хамгаалах шууд чиг үүрэг гүйцэтгэх 5684 алба хаагчдын 89.7 хувь нь дуулга малгайгаар, 64,4 хувь нь хамгаалалтын хантаазаар, 66,8 хувь нь тусгай өмсгөлөөр, 15,9 хувь нь хорт утааны багаар, 88,3 хувь нь резинэн бороохойгоор, 79,1 хувь нь бугуйн гаваар, 65,1 хувь нь цахилгаан бороохойгоор, 100 хувь бамбайгаар хангагдаад байна,¹⁴⁶ гэсэн судалгаа тоо баримт байна.

Хэдийгээр цагдаагийн анги байгууллага, алба хаагч нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /каска-хамгаалалтын малгай, хамгаалалтын бамбай, өвдөг тохойвч, хамгаалалтын иж бүрэн өмсгөл/ болон олон нийтийн замбараагүй байдал үүссэн үед тараах зорилгоор хэрэглэх өндөр даралттай усаар шүрших тусгай зориулалтын усан хөөрөгт машин зэргийг авч, шаардлагатай үед хэрэглэх зорилгоор бэлтгэл сургуулилт хийж байгаа боловч, бидний ажиллагаанд оролцохдоо өмсөж ашиглаж байгаа хамгаалах хэрэгслүүдийн үзүүлэлт, чанар, стандартыг

¹⁴⁵ Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29 /794/

¹⁴⁶ ЦЕГ-ын Санхүү ар талын газрын тайлан 2011 он

тодорхойлсон албан ёсны мэргэжлийн байгууллагын дүгнэлт одоо болтол байхгүй байгаа нь бидэнд ихээхэн хүндрэл учруулж байна.

Цагдаагийн албанд ашигладаг хамгаалах тусгай хэрэгслүүдийн чанар, стандартыг дотооддоо тогтоож бий болгон мөрдөж ажилласнаар цаашид алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй албан үүргээ итгэлтэй гүйцэтгэх боломж бүрдэх юм.

Энд сонирхуулахад 1914 оны 07 дугаар сарын 15(28)-нд Сербийн Сараево хотод Австри-Унгарын эзэнт гүрний хунтайж Франц Фердинанд руу халдаж, амийг нь хөнөөсөн нь хүн төрөлхтөнд гамшиг (5.6 сая хүн амь үрэгдсэн) учруулсан Дэлхийн I дайны шалтаг болсон.

Хамгийн гол нь хунтайжийн өмссөн хамгаалах хантааз нь түүний амийг хамгаалж чадаагүй гэж мэргэжилтнүүд дүгнэдэг аж.

Эцэст нь цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах, эрсдлийг бууруулахад хамгаалах тусгай хэрэгслийн үүрэг

оролцоо их чухал байр суурь эзлэх болно гэж харж болохоор байна. Энэхүү асуудлын хүрээнд дараах цөөн хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчдын албанд ашиглаж байгаа хамгаалах тусгай хэрэгслийн чанарыг мэргэжлийн стандарт хэмжил зүйн төв лабораториар оруулж баталгаажуулах

2. Цагдаагийн төв байгууллага албандаа ашиглах хамгаалах тусгай хэрэгслийг олон орны цагдаагийн албанд ашиглаж байгаа тусгай хэрэгслүүдтэй харьцуулан судалж, судалгаа хийсний эцэст авч ашиглаж байх

3. Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдад хамгаалах тусгай хэрэгслийг хүрэлцэхүйц хэмжээгээр авч нийт алба хаагчдыг бүрэн хангах

4. Хамгаалах тусгай хэрэгслийг шалгахдаа ХСИС-ийн ШУТГ болон Шинжлэх ухааны академийн холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран ажиллах

Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ БА ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА LEGAL REFORM AND POLICE



Б.Баянмөнх. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхмийн ахлах багш, цагдаагийн ахмад

Bayanmunkh.B. Police captain, Senior Lecturer of the Police law faculty, Law Enforcement University

Abstract: There are many difficulties in and reforms. In this article the author has tried to show that all reforms should be based on results of research and advisement on reforms should be done by media widely. Psychological acceptance in society. Is very important moment in the reform. There are some interactive point concerning social psychology.

шилжээд хорь гаран жил болсон мөртлөө цэрэг, цагдаа, шүүх гээд аюулгүй байдлыг сахин хамгаалах байгууллагуудынхаа тогтолцоог өнөөгийн нийгэмд нийцүүлэн шинэчлэх талаар далайцтай өөрчлөлт хийж амжаагүй удсан билээ.

Холбогдох хуулиудыг ганц нэгээр нь өөрчилж,

зарим талаар эрхзүйн орчин нь шинэчлэгдэж ирсэн боловч яг бүтэц, тогтолцооныхоо хувьд өмнөх нийгмийн хэв шинжийг хадгалсаар ирсэн. Шинэчлэлийн үзэл санаа туссан хэсэг бусад оролдлого хийж ирсэн боловч цогцоор нь өөрчилж чадаагүй